

# The Baptist Tabernacle of Los Angeles

1329 South Hope Street, L.A. Civic Center

Mailing Address:  
P. O. Box 15308  
Los Angeles, CA 90015  
Phone: (213) 744-9999

E-mail: [rhymersjr@sbcglobal.net](mailto:rhymersjr@sbcglobal.net)  
[www.sermonsfortheworld.com](http://www.sermonsfortheworld.com)  
[www.baptisttabernacle.com](http://www.baptisttabernacle.com)



Dr. R. L. Hymers, Jr.  
Founding Pastor

Dr. Christopher L. Cagan  
Pastor

Арван хоёрдугаар сар, 2019

Эрхэм анд минь:

Би та нартаа баяр хөөртэй Христмасс мэндчилгээ илгээж чадах байсан. Гэхдээ шудрага байх үүднээс өнгөрсөн нэг жил хагас гаруй хугацаанд бид маш аймшигтай чуулганы хагарал дундуур туулж ирснийг би хэлэх ёстой.

Энэ өнгөрсөн жилээс хэдэн сарйн өмнө эхэлсэн. Манай ахлах удирдагч нэгэн өөр пастортой нууц уулзалт хийж эхэлсэн. Тэдний хоёр нь манай чуулганыг устгах төлөвлөгөө сэдсэн. Тэдний хоёр нь биднээс аль болох олон хүнийг уруу татаад өөр нэгэн чуулган эхлүүлэх төлөвлөгөөтэй байсан. Тэр үед чуулганы гол хагаралаас зайлсхийхэд дэндүү оройтсоныг болохыг би олж мэдсэн.

Энэ ууртай ахлагч намайг “халз-тулаан”-д татан оруулах зүйлийг хийж эхэлсэн. Би түүнтэй тэмцэлдэхээс зайлсхийх үед тэр чуулганыг орхин явсан. Төд удалгүй бусад нь дагаад явсан. Ахлагчдын удирдагч тэр өөрийнхөө вебсайтад өөрийн порно зургуудийг оруулсан. “Салан явагсад”-ын нэг эдгээр зургуудаар намайг айлгах гэж оролдсон, тэгээд цагдаад мэдэгдсэн. Ахлагчдын удирдагч болон түүний эхнэр манай чуулганыг орхисон.

Тэр цагт тэргүүн ахлагч маш нээлтэйгээр идэвхтэй болж эхэлсэн. Тэгээд тэр манай чуулганыг орхиж, аль болох их хэмжээгээр бидний нэг хэсгийг салгаад авч явсан. Энэ тэргүүн ахлагч олон жилийн турш манай чуулганд удирдах түвшинд байсан учраас олон хүн түүнийг даган чуулганыг орхин явсан. Хуваагдал дуусах тэр үеэр манай чуулганы тал хувийг өөртөө татах боломжтой болсон.

Тэр үеэр миний биеийн байдал доройтож байсан бөгөөд би Ням гарагийн хоёр цуглаан дээр хоёуланд нь номлох боломжгүй болсон. Нэг сургуулийн оюутан Ням гарагийн өглөө номлож байсан. Гэхдээ түүний дотно найзууд нь орхиод явсан тэр үед тэрээр надтай хамт зогсоход дэндүү туршлагагүй байсан. Хоёрдугаар сарын 20-ны өдөр энэ залуу надтай холбоогоо тасалсан. Тэр ээжтэйгээ хамт чуулганыг орхиод шинэ-евангелст чуулгануудад оролцох болсон. Энэ залуу номлогчтой дотно андын харилцаатай байхад би зарцуулсан цаг нь миний хувьд дэндүү их байсан. Хоёрдугаар сарын 23-нд би Др Кристофер Каганыг пастораар томилж, тэр ажлаа эхэлсэн. Би Хүндэт Пастораар томилогдсон. Би цуглаанд оролцоход дэндүү бие сул байсан. Гуравдугаар сарын 3-ны өдөр Др Каган миний тэтгэвэрт гарч буй болон өөрийгөө пастораар томилогдсоныг зарласан. Др Каган бол Пастор Вурмбрэндээс бусад пасторуудаас хавьгүй илүү агуу Христ итгэгч юм. Түүний манлайлалгүйгээр манай чуулган хөл дээрээ босож чадахгүй байх байсан.

Гэхдээ сайн зүйлс ч бас тохиолдсоор байсан. Нэгдүгээр сарын 26-ний өдөр манай сайтад 41 дэх хэл нэмэгдсэн. Мөн тэр өдөр (Нэг сарын 26) манай “апп” АйФоне болон Андроид утсанд татах боломжтой болсон. Үүнээс хойш дэлхий даяарх хэдэн мянган хүмүүс энэхүү “апп”-аар дамжуулан бидэнтэй нэгдэх болсон бөгөөд Нью-Йорк дахь Иудейчүүд рүү илгээгдсэн найз нар маш их талархалаа илэрхийлсэн. Тэгээд удалгүй Африк тивийн гол хэл болох Малави хэлээр – 42 дахь хэл болж нэмэгдсэн. Хоёрдугаар сарын 23-нд Др Каган албан ёсны пастор болж, би Хүндэт Пасторын байранд тавигдсан.

Дашрамд дурьдахад, Би энэ өвчнөөсөө болоод үнэхээр сульдаж, бие өвдөж байсан. Би өөрийн ханьдаа үнэхээр талархаж байна – энэ бүх үеийн турш үргэлж хажууд минь хамт байгаад. Би тэнхэрхийн тулд Хоёрдугаар сарын 27-ноос Гуравдугаар сарын 20 хүртэл эхнэрээ аваад Аризона руу урт хугацааны амралтаар явсан. Гуравдугаар сарын 20-д би буцаж ирээд Ням гарангийн орой номлож, Бямба гарагийн орой сургаал заасан.

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 42 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**

Үүнээс хойш манай чуулганы байрыг худалдах зарыг тавьсан. Дөрөвдүгээр сарын 14-нд миний 78 насны ойн баярыг хуучин байранд тэмдэглэсэн. Тавдугаар сарын 7-д манай чуулганы итгэмжит залуучуудад зориулсан дагалдагчдын бүлгэмийг манай товхимолд байдаг “Евангелизмийн Тэсрэлт” шиг ашиглахаар эхлүүлсэн. Тавдугаар сарын 22-29-нд Др Каган намайг эхнэртэй минь аваад Сан Франциско дахь Хятад Баптист чуулган болон түүний найрсаг пасторын зочлуулсан. Мөн бид Марин Коунтрид миний эхлүүлсэн чуулганд удаан хугацаанд пастор хийж буй Майк болон Мона Рилей нартай уулзсан. Майк намайг маш ихээр зоригжуулсан бөгөөд тэдний чуулганы 50 жилийн ойгоор илтгэл тавихаар уригдсан. Бусад хүмүүс надад таатай хандаагүй, харин ч манай чуулганы хуваагдалд намайг буруутгаж, өвчнөөс минв илүүтэйгээр намайг шаналахад хүргэсэн.

Долдугаар сарын 28-нд бид Др Каганы 66 насны төрсөн өдрийн нийллэгийг чуулгандаа тэмдэглэсэн. Энэ үеэр “Лос-Анжелсийн Агуу Хятад Баптист Чуулган” хэмээн нэрлэгдэх төлөвтэй байгаа Сан Габриел Валли дахь манай шинэ чуулган зарлагдсан. Бид шинэ барилга худалдан авч байгаа бөгөөд удахгүй гурвалсан гэрээ дуусгавар болж хаагдах болно.

Долдугаар сарын сүүлээр би гэргий Химерсээ дагуулаад далайн эрэг дээр богино хугацааны амралт авсан. Миний хань Илеана бол бүх дэлхий даяарх хамгийн шилдэг пасторын гэргий гэдэгт би огтоос эргэлздэггүй. Би хүү Роберт Леслиетэйгээ хамт түүнийг гэр бүлийнхэнтэй нь хамт Израйль руу явуулсан. Арваннэгдүгээр сарын 17-ноос Ням гарагийн өглөө болон орой цуврал номлолуудаа хийж эхэлсэн. Энэ бол Ням гаргийн хоёр цуглаанд урт хугацаагаар номлох эрүүл мэндийн хувьд боломжтой болсон анхных юм. Др Каганы манлайлал болон шаргуу хөдөлмөрийн үрээр хоёр залуу аврагдаж, хэд хэдэн Хятад оюутнууд манай чуулганд оролцож эхэлсэн. Др Каган хотын төв дэх өөрийн байшингаа зараад Сан Габриелын байрны ойролцоо өөр байшин авахаар хайж байгаа. Ирэх саруудад бид шинэ байр руу чуулганаа нүүлгэх болно.

Чуулганы хуваагдал дууссан гэж санагдаж байан. Хэд хоногийн өмнө Хотын Найдвар Хавдрын Төвд миний хавдар эдгэрсэн юм шиг байна гэдгийг хэлсэн. Др Каган болон эхнэр бид нар хамтдаа манай гэрт Талархалын баярыг манай хүүхдүүд, ач нар, энэ их хямралын үед бидэнтэй хамт зэрэгцэн зогссон тэдний ихэнхтэй нь хамт тэмдэглэсэн. Бид хамтдаа маш гайхалтай цагийг өнгөрөөсөн!

Бурхан та бүгдийг ивээх болтугай! Бид Хятад Чуулганыг эхлүүлэх үед бидний төлөө залбирахыг бодоорой!



Би гэр бүлээрээ үнэхээр бахархадаг. Зүүнээс баруун тийш Весли, Лесли, бяцхан Ханна, би өөрөө, Илеана Сарагийн хүүхэдтэй, Леслигийн гэргий Жин, Илеананы ээж Линда, түүний ах Ервин Куеллар.

Бидний Аврагч Есүс Христ магтагдах болтугай!

Р.Л Химерс Жр.,  
D.Min., Th.D., Litt.D.  
Филиппой 4:13

“Амьдын газарт ЭЗЭНий сайн сайхныг харна гэж би итгэсэн. ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн. Хүчтэй байж, зүрхээ зоригтой боллогтун. Тийм ээ, ЭЗЭНийг хүсэн хүлээгтүн” (Дуулал 27:13-14).

**МАНАЙ НОМЛОЛЫН ВЕБСАЙТ НЬ 42 ХЭЛЭЭР ҮГ БҮРЧЛЭН ОРЧУУЛСАН ХЭДЭН ЗУУН НОМЛОЛУУДЫГ [WWW.SERMONSFORTHEWORLD.COM](http://WWW.SERMONSFORTHEWORLD.COM)-ООР САНАЛ БОЛГОЖ БАЙГАА.**